



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/433

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Нийтийн биеийн тамир, спортын хөгжүүлэх тухай” 53 дугаар зарлиг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн бие бялдрын түвшингээ хянах, эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургах, дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилгоор хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд 2021 оны 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Энхтөр )-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100921

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 09  
дугаар сарын 14-ны өдрийн 211/2021 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



**САРЫН АЯНЫ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхтөр (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Бат-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын арга зүйч)

Гишүүд: Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)

Ж.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)

Ц.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

С.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын албаны дарга)

Ц.Содномдорж (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын Залуучуудын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 09  
дугаар сарын 11-ны өдрийн 433 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**“ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ, ЧИЙРЭГЖИЛТИЙН  
ТҮВШИН ТОГТООХ СОРИЛЫН САР”-ЫН АЯНЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

Нэг. Зорилго: COVID-19 цар тахлын үед иргэдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, дасгал хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Зохион байгуулагч: Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газар

Хугацаа: Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын сарын аяныг аймгийн хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал зохион байгуулна.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Байгууллагын спорт хамтлагийн ахлагч болон гишүүд нь тухайн байгууллагын алба хаагчдаа 100% хамруулж бие бялдрын түвшин тогтоох сорил авах бэлтгэл ажлыг ханган, хамтран зохион байгуулна.

3.2. Аймгийн хэмжээнд байгууллагын албан хаагчид, 3-64 насны иргэдийн дунд 3-5, 6-8, 9-11, 12-17, 18-64 гэсэн насны бүлгээр, сайн дурын үндсэн дээр, иргэдээс сорил авч, насны ангиллаар тайлан мэдээг Биеийн тамир, спортын газарт цахим мэдээллийн санд нэгтгэнэ.

3.3. Сорилд цэрэг хүчний байгууллагын алба хаагчид бүрэн хамрагдсан байх бөгөөд нийт сорилд хамрагдсан иргэдийн 15-45 насны иргэдийн эзлэх хувь 30 хувиас багагүй байна.

3.4. Сорилд хамрагдах хүсэлтэй 3-64 насны иргэдийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар түгээж, аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын Биеийн тамирын албаны 201 тоот өрөө болох “Иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх, зөвлөгөө өгөх танхим”-д ирж сорилоо өгөх боломжтой. Сорилд сайн дурын үндсэн дээр хамрагдаж, сорилын мэдээллийн санд бүртгэгдсэнээр биеийн ерөнхий хөгжлийн түвшингээ хянах боломжтой.

3.5. Бие бялдрын түвшин тогтоох стандартад оруулах сорилын шалгуур үзүүлэлт, арга, аргачлалын талаар санал, зөвлөмжийг ирүүлж болно. /Холбоо барих утас: 89032932/